



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 20 өдөр

Дугаар А/36

Модот

Газар ашиглуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3, 44 дүгээр зүйлийн 44.5, 44,6 дахь заалт, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 18-ний өдрийн 24 дугаар тогтоолын 6 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын нутаг дэвсгэрт уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй, гадаадын хөрөнгө оруулалттай Эй Эйч Жи Металс групп ХХК-д 3-р баг Баянмодны баруун аманд 50232116 нэгж талбарын дугаартай, 1015,7га газар 5 жилийн хугацаатай ашиглуулсугай.

2.Газар ашиглах гэрээ байгуулж, гэрчилгээ олгож, гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг газрын даамал (Я.Отгонтуяа)-д үүрэг болгосугай.

3. Газар ашиглах гэрээг жил бүр дүгнүүлж, Газрын төлбөрийг хугацаанд төлж ажиллахыг Эй Эйч Жи Металс групп ХХК захиралд үүрэг болгосугай .

ЗАСАГ ДАРГА



А. МӨНХ-ОРГИЛ